

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 2/07

Чойр

Зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Захиргааны ерөнхий хуулийн 43.1, 43.2, Хөдөлмөрийн дотоод журмын 6.5, 6.7 заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Даргын зөвлөлийн бүрэлдэхүүнийг дор дурдсанаар байгуулсугай. Үүнд:

ДАРГА

Байгууллагын дарга

ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН

ДАРГА:

Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хариуцсан мэргэжилтэн

ГИШҮҮД:

Захиргаа, аж ахуйн албаны дарга

Мал үржлийн албаны дарга

Үйлдвэр, худалдаа, үйлчилгээний

албаны дарга

2. Даргын зөвлөл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний биелэлтийг улирал, хагас, бүтэн жилийн дүнгээр, албадын, төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний биелэлтийг, ёс зүйн зөвлөл, бусад дотоод зохион байгуулалтын нэгж, багуудын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан болон ажиллах журмын дагуу асуудлыг хэлэлцэх, шийдвэр гаргахдаа төрийн хууль тогтоомжийн хүрээнд хариуцлагатай ажиллахыг үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2017 оны Б/12 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Н.ДАВААХҮҮ

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 03 сарын 27 өдөр

Дугаар А/18

Чойр

Дотоод хяналтын багийг шинэчлэн
байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Захиргааны ерөнхий хуулийн 43.1, 43.2, Хөдөлмөрийн дотоод журмын 2.7 заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дотоод хяналтын багийн бүрэлдэхүүнийг дор дурдсанаар байгуулсугай. Үүнд:

БАГИЙН АХЛАГЧ:

Мал үржлийн албаны дарга

ГИШҮҮД:

Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын мэргэжилтэн

Газар тариалангийн үйлдвэрлэл хариуцсан мэргэжилтэн

2. Дотоод хяналтын багийн бүрэлдэхүүнд журмаа баримтлан, хариуцлагатай ажиллахыг үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуйн газрын 2013 оны А/20 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай

ДАРГА



Н.ДАВААХҮҮ

ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 9/12

Чойр

Ёс зүйн зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Захиргааны ерөнхий хуулийн 43.1, 43.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5, Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн 6 дах хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын ёс зүйн зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:

Мал үржлийн албаны мэргэжилтэн

ГИШҮҮД:

Хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод
аудитын мэргэжилтэн

Хүнсний үйлдвэрлэл, нийтийн хоол
хариуцсан мэргэжилтэн

2. Ёс зүйн зөвлөл нь томилогдсон өдрөөс хойш 3 жилийн хугацаанд Төрийн албаны хууль болон “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг хэлбэрэлтгүй мөрдөж ажиллахыг үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан ХХААГ-ын даргын 2018 оны Б/09 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Н.ДАВААХҮҮ